

Дээврийн ажлын ТББ

БАТЛАВ:

ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГА Д.СОЁЛЧХҮҮ

ОРХОН АЙМГИЙН ЗДТГ

Огноо: 2019.05.09

АЖИЛ ГҮЙЦЭТГҮҮЛЭХ ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ

Төслийн нэр: Орон сууцны 3-р хороолол 23-р байр 2-р блокын дээвэр

Төслийн дугаар: OP-28/2019

Тендерийн материал бэлтгэсэн:

Эрдэнэт хот

2019 он

Дээврийн ажлын ТББ

НЭГ.ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

Огноо: 2019.05.09

Тендер шалгаруулалтын нэр: Орон сууцны 3-р хороолол 23-р байр 2-р блокын дээвэр
Тендер шалгаруулалтын дугаар: ОР-28/2019

Орхон аймгийн ЗДТГ нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос "Орон сууцны 3-р хороолол 23-р байр 2-р блокын дээвэр" ажлыг гүйцэтгэх тухай цахим үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Энэхүү ажлын тендер шалгаруулалт нь төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр зарлагдаж байгаа хялбаршуулсан цахим тендер тул (www.tender.gov.mn) хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг үнэ төлбөргүй татаж авна уу.

Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө 30 000 (Гучин мянган) төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байна.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулинд нийцүүлэн тендерийн баримт бичигт тодорхойлсон журам болон Харьцуулалтын аргаар гүйцэтгэгчийг сонгоно.

Үнийн саналын баримт бичигт зураг, төсөв, техникийн тодорхойлолт, тавих шаардлагыг хавсаргасан болно.

Энэ урилгад заагдаагүй бусад нөхцөлийг тендерийн баримт бичигт тусгасан болно.

Тендерийг **2019 оны 05 дугаар сарын 17-ний өдрийн 08 цаг 30 минутаас** өмнө төрийн худалдан авах ажиллагааны цахим [/www.tender.gov.mn/](http://www.tender.gov.mn/) системд илгээх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2019 оны 05 дугаар сарын 17-ний өдрийн 09 цаг 00 минутанд** нээнэ.

Дотоодын давуу эрх тооцно.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

[Орхон аймаг ЗДТГ 113 тоот, Орон нутгийн өмчийн газар 70358570]

Хоёр. **ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА**

- | | |
|---|---|
| 1. Эрх бүхий тендерт оролцогч | 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна. |
| 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт | 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ. |
| 3. Тендерийн иж бүрдэл | 3.1. Тендерт оролцогчдод өгсөн зааварчилгааны дагуу бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ:

1. Үнийн санал;
2. Үнэлэгдсэн үе шатны ажлын хуваарь
3. Улсын бүртгэлийн гэрчилгээг эх хувиас скайнердаж ирүүлэх
4. Тусгай зөвшөөрлийн гэрчилгээг, гэрээний хамт эх хувиас скайнердаж ирүүлэх
5. Тендерт оролцогчийг төлөөлөлж гарын үсэг зурах этгээдийн итгэмжлэлийг эх хувиас скайнердаж ирүүлнэ. Итгэмжлэгчийн цахим иргэний үнэмлэх эх хувиас скайнердаж ирүүлэх
6. Харьяа татварын байгууллагын тодорхойлолт эх хувиас скайнердаж ирүүлэх-/тендер нээсэн өдрөөр өр төлбөргүй байх/.Мөн тендер нээсэн өдрөөр Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээс өр төлбөрийн тодорхойлолтийг татаж шалгах бөгөөд өр, төлбөртэй байвал шууд татгалзана.
7. Харилцагч банкны тодорхойлолт эх хувиас скайнердаж ирүүлэх /өр төлбөр болон зээлийн талаарх мэдээллийг харилцагч банк бүрээр/
8. Нийгмийн даатгалын байгууллагын тодорхойлолт эх хувиас скайнердаж ирүүлэх /даатгуулагчийн тоо, өр төлбөргүй талаарх/
9. Шүүхийн магадлагаа эх хувиас скайнердаж ирүүлэх
10.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын лавлагаа эх хувиас скайнердаж ирүүлэх.
11. Тендерт оролцогч нь Засгийн газрын 2019 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 90 дугаар тогтоолын хавсралтад тусгагдсан дотоодод үйлдвэрлэсэн чанар стандартын шаардлага хангасан бараа, барилгын материалуудыг дотоодын үйлдвэрээс авч ашиглах бөгөөд түүнийг нотлох бичиг баримт заавал ирүүлнэ. |

12. Сүүлийн 2 жилийн ажлын гүйцэтгэлийн жагсаалт, үнийн дүн, гэрээ, хүлээлгэн өгсөн актыг эх хувиас скайнердаж ирүүлэх
13. Баталгаажсан, аудитлагдсан 2018 оны санхүүгийн тайлан, дүгнэлтийн хамт эх хувиас скайнердаж ирүүлэх
14. Нийженер, техникийн ажилтнуудын судалгаа диплом, мэргэжлийн үнэмлэх, цахим үнэмлэхний хуулбарыг эх хувиас скайнердаж ирүүлэх.
15. Ажлын тоо хэмжээ, ажлын зургийн дагуу тооцсон төсөвтэй, эрх бүхий төсөвчнөөр баталгаажсан байна.

Жич: Магадлашгүй ажлын зардал, Захиалагчийн хяналтын зардал, зохиогчийн хяналтын зардал зураг төсөв, норм нормативийн сангийн зардлыг төсөвт зохих зааврын дагуу, мөн татвар, хураамжийг холбогдох хуулийн дагуу тус тус тооцож ирүүлэх ба зураг төсвийн үнийг хяналтын төсөвт тусгаснаар тооцож ирүүлнэ.

16. Тендерийн баримт бичгийн гэрээний ерөнхий болон тусгай нөхцөл, маягт зэргийг зөвшөөрч байгаа талаар мэдэгдэл эх хувиас скайнердаж ирүүлэх
17. Захиалагч татвар, нийгмийн даатгал, харилцагч банк болон бусад холбогдох байгууллагаас тодорхойлолт хүсэхэд татгалзах зүйлгүй гэсэн тодорхойлолт эх хувиас скайнердаж ирүүлэх.
18. Тендерт оролцогч нь тендерийн жишиг маягтуудаас зохих маягтыг ашиглан тендерийн санал ба үнэлэгдсэн үе шатны ажлын хуваарийг бэлтгэж ирүүлнэ. Эдгээр маягтын үг, өгүүлбэрт утга агуулгыг нь өөрчилсөн буюу орхигдуулсан аливаа өөрчлөлт хийхийг зөвшөөрөхгүй. Маягт дахь бүх хоосон зайд шаардсан мэдээллийг нөхөж бичих бөгөөд дутуу ирүүлсэн, өөрчилж ирүүлсэн магтыг хүчингүйд тооцно. Мөн тендерт ирүүлсэн тодорхойлолтууд нь тендер зарлагдсан өдрөөс хойш авсан байна.

4. Тендерийн үнэ

- 4.1. Тендерийн үнэд тодорхойлсон нийт ажил хамрах ба тендерт оролцогчийн үнэлж ирүүлсэн үе шатны ажлын хуваарьт үндэслэнэ. Үе шатны ажлын хуваарь нь ажил гүйцэтгэх хугацааны графиктай уялдсан байх шаардлагатай
- 4.2. Тендерт оролцогч үнийн хөнгөлөлтийг тендерт тусган санал болгож болно.
- 4.3. Тендерт оролцогч нь зураг болон техникийн тодорхойлолтод тодорхойлогдсон ажлыг үнэлэхдээ үе шатны ажлын хуваарьт хураангуй байдлаар өгөгдсөн бүх нэр төрөлд нэгж үнэ болон нийт үнэ санал болгоно. Тендерт оролцогч аль нэг нэр төрлийн нэгж үнэ болон нийт үнийг бөглөөгүй орхисон тохиолдолд түүнийг гүйцэтгэсний төлбөрийг захиалагч хийхгүй ба бусад нэр төрлийн үнэд багтсан гэж үзнэ.

- | | |
|--|--|
| | <p>4.4. Тендерт оролцогч нь тендер хүлээн авах эцсийн хугацаанаас 14 хоногийн өмнө хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн дагуу энэ гэрээ болон бусад үндэслэлээр гүйцэтгэгчийн төлөх ёстой бүх татвар, хураамж, бусад төлбөрийг тендерийн нийт үнэд багтаасан байна.</p> <p>4.5. Тендерт оролцогчийн ирүүлсэн саналыг олон нийтэд мэдээлэхэд татгалзах зүйлгүй тухай тендерт оролцогчийн албан мэдүүлэг ирүүлнэ.</p> |
| 5. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа | <p>5.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 45 хоногийн хугацаанд хүчинтэй байна.</p> |
| 6. Алдааг зарцуулах | <p>6.1. Захиалагч шаардлагад нийцсэн тендерийн арифметик алдааг шалгаж дараах байдлаар зарцуулна:</p> <ul style="list-style-type: none">(а) тоо болон үсгээр илэрхийлэгдсэн дүн хоорондоо зөрсөн бол үсгээр илэрхийлэгдсэнийг зөв гэж үзнэ;(б) үе шатны ажлын үнийн нийлбэр тендерийн маягтад заасан тендерийн нийт үнээс зөрвөл үе шатны ажлын үнийн нийлбэрийг үндэслэн тендерийн нийт үнийг зарцуулна;(в) нэгж үнийг ажлын тоо хэмжээгээр үржүүлж гаргасан нэг мөр дэх нийт дүнд зөрүү гарвал нэгж үнийг давамгайлах гэж үзнэ. Гэхдээ захиалагчийн үзэж байгаагаар нэгж үнэд аравтын орны таслалыг андуурсан болох нь илэрхий байвал тухайн мөр дэх нийт дүнг зөв гэж үзэн холбогдох нэгж үнийг зарцуулна. <p>6.2. Захиалагчийн зарцуулсан тендерийн дүнг тендерт оролцогчийн зөвшөөрлөөр эцсийнх гэж үзнэ. Хэрэв тендерт оролцогч зарцуулсан дүнг хүлээн зөвшөөрөхгүй бол захиалагч түүний тендерээс татгалзана.</p> |
| 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх | <p>7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.</p> <p>7.2. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдийн үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.</p> |
| 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл | <p>8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө утсан холбоогоор мэдэгдэж, албан бичгээр баталгаажуулна. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь зарцуулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.</p> |

Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТОӨЗ-НЫХОЛБОГДОХ ЗААЛТ	Шалгуур үзүүлэлт
ТОӨЗ 1.1	<p>1.Тендерт оролцогчийн бэлтгэн ирүүлсэн материал нь ТОӨЗ-ны 3, 4-т заасан иж бүрдлээс бүрдсэн байна.</p> <p>2.Тендерт оролцогч тухайн ажилд шаардлагатай дараах тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагатай. Үүнд: хуучнаар-2.1.1, шинэ журмаар БА-8.1 зөвшөөрөлтэй байх ба гэрээний хамт хүчинтэй байна.</p> <p>3.Дараах үндсэн тоног төхөөрөмжийг ажлыг гүйцэтгэх хугацаанд (өөрийн, түрээслэх, хөлслөн авах г.м.) бэлэн байлгах шаардлагатай. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Авто кран - Ачааны авто машин - Зуурмаг зуурагч - Газын хошуу - Газо пропан <p>Гэрээт ажилд ашиглах машин механизмыг, тоног төхөөрөмжийн гэрчилгээний хуулбарыг ирүүлнэ.</p>
ТОӨЗ 13.2	<p>Жич: Тендерт оролцогч нь ТББ-тэй бүрэн танилцсан байх шаардлагатай бөгөөд тендерийг цахим хэлбэрээр илгээхдээ бэлтгэсэн материалын товьёогын дагуу бүх файлыг /PDF/ файлаар ирүүлнэ.</p> <p>Тендерийн баримт бичгийг дутуу, товьёогийн дагуу бус болон PDF-ээс өөр файлаар ирүүлсэн тендерээс татгалзана.</p>
ТОӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь: Огноо: 2019 оны 05 дугаар сарын 17-ны өдөр. Цаг: 08 цаг 30 минут</p> <p>Тендерийн материалыг Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn) хаягаар ААН-ийн хувийн тоон гарын үсгийг ашиглан нэвтэрч цахим (PDF) файл хэлбэрээр илгээнэ. Цахим систем ашиглан илгээх нийт файлын хэмжээ 100 Mb, нэг файлын хэмжээ 15 Mb байна.</p> <p>Мөн ТББ-т шаардсан баримт бичгүүдийн Эх хувиас скайнердаж ирүүлснийг ЭХ ХУВЬ гэж тооцох бөгөөд нотариатаар баталгаажуулсан баримт бичгийг эх хувьд тооцохгүй. Эх хувийг ямар нэгэн хэлбэрээр хуурамчаар үйлдсэн тохиолдолд тендерээс шууд татгалзаж, эрх бүхий байгууллагад хандаж “Тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэл хамруулна</p>
ТОӨЗ 2.1	<p>Тендерийн нээлт хийх газрын хаяг нь дор өгөгдөв. Үүнд:</p> <p>Байшин, гудамжны нэр: Орхон аймгийн ЗДТГ, Нутгийн Удирдлагын ордон</p> <p>Давхар болон өрөөний дугаар: ЗДТГ-ын 1-р давхарт, Нэг цонхны үйлчилгээ, ХААА-ны сургалт, мэдээллийн танхим</p> <p>Аймаг, хот: Орхон аймаг</p> <p>Улс: Монгол Улс</p> <p>Тендерийн нээлт хийх огноо, цаг нь: Огноо: 2019 оны 05 дугаар сарын 17-ны өдөр. Цаг: 09 цаг 00 минут</p>
ТОӨЗ 6.2	Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: багцгүй

БАТЛАВ:

ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГА Д.СОЁЛЧХҮҮ

Дөрөв. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

- Барилга угсралтын ажлыг “Барилгын тухай хууль” болон холбогдох бусад хууль тогтоомж, стандарт, норм нормативын баримт бичгийн шаардлагад нийцүүлэн гүйцэтгэх;
- Барилга угсралтын ажлыг стандарт, норм нормативын баримт бичиг, зураг төслийн шаардлагын дагуу гүйцэтгэх;
- Шаардлагатай барилга байгууламжийг барих үйл ажиллагаа, технологиос нь хамааруулан АГТ /Ажил гүйцэтгэх төсөл-АГТ/, УЗБТ /Үйлдвэрлэл зохион байгуулалтын төсөл-УЗБТ/-ийг боловсруулан барилга угсралтын ажил гүйцэтгэх;
- Олон улсын болон үндэсний стандартын шаардлага хангагүй, гарал үүсэл, тохирлын гэрчилгээгүй барилгын материал, эдлэхүүн болон зориулалтын бус тулаас, хэв хашмалыг барилга угсралтын ажилд хэрэглэхгүй байх;
- Техникийн тодорхойлолттой танилцаж, түүнд заагдсан шаардлагуудыг ханган ажиллахыг зөвшөөрч байгаа тухай мэдэгдлийг албан бичгээр эх хувиар ирүүлнэ
- Тендерт шалгарч гэрээ байгуулсан боловч техникийн тодорхойлолтын шаардлагыг биелүүлээгүй нөхцөлд захиалагч эрхийнхээ дагуу ажлыг зогсоож зөрчлийг арилгуулсны үндсэн дээр ажлыг үргэлжлүүлнэ./зөвшөөрсөн мэдэгдэл эх хувиар ирүүлнэ/.
- Барилга угсралтын ажлыг чанар аюулгүй байдал, хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн шаардлагад нийцүүлэн гүйцэтгэх;
- Монгол улсын норм стандартын шаардлага хангасан байх / MNS ASTM D 412 – 2013 **Шингэн зүйлийн нөлөөллийг тодорхойлох арга MNS ASTM D 471 - 2013 Урагдалтын бат бэхийг тодорхойлох арга ГОСТ30547-97 СНиП 23-01 дүйцэхүйц чанарын шаардлагатай байна.**

1. Ажлын талбай, түүний байршил, нөхцөл байдалтай газар дээр нь танилцсан байх
2. Тухайн ажлыг гүйцэтгэхдээ норм ба дүрэм стандартыг барьж ажиллах
3. Мөн бүх материал нь шинэ, ашиглагдаагүй, сүүлийн үеийн эсхүл орчин үеийн загварын сүүлийн үеийн хандлагыг хангасан байна.
4. Ажлыг гүйцэтгэх нарийвчилсан графикийг гаргаж батлуулах.
5. Ажлыг гэрээт хугацаандаа чанарын шаардлагыг хангаж, бүрэн гүйцэтгэх.
6. Ажил эхлэх зөвшөөрлийг авах баримт бичгийг бүрдүүлж барилга техник хяналтын улсын байцаагчид хүргүүлж, зөвшөөрлийг гүйцэтгэгч өөрөө авна.
7. Гүйцэтгэгч үе шатны ажлын үед зохиогч болон захиалгчийг дуудаж далд ажлын

- акт үйлдэж баталгаажуулна.
8. Гүйцэтгэгч нь хөдөлмөр хамгаалал, техникийн аюулгүй ажиллагааны нөхцөлийг бүрэн хангаж, үүнээс гарах хор хохирлыг өөрсдөө хариуцна.
 9. Ажлын тоо хэмжээг сонгон шалгаруулалтанд оролцогчийн удирдамж, гэрээний ерөнхий болон тусгай нөхцөл, техникийн тодорхойлолт болон зурагтай холбож ойлгоно.
 10. Энд гаргасан ажлын тоо хэмжээг сонгон шалгаруулалтын үндсийг тавих үүднээс урьдчилан тооцоолж гаргасан. Бодитойгоор захиалсан ажлыг гүйцэтгэгч хийж гүйцэтгэн хийсэн ажлынхаа гүйцэтгэлийг гарган захиалагчаар хянуулан баталгаажуулна. Энэ нь төлбөр хийгдэх үндэс болно.
 11. Гэрээнд тусгайлан заагаагүй тохиолдолд тендерийн саналын үнэлсэн ажлын тоо хэмжээнд тусгагдсан үнэлгээ болон үнэ нь барилгын ажлыг явуулахад шаардагдах тоног төхөөрөмж, хүн хүч хяналт, материал, ашиг татвар хураамж болон гэрээний хүрээнд хүлээх ёстой үүрэг хариуцлагыг хамруулсан байна.
 12. Үнэлсэн ажлын тоо хэмжээнд тусгагдсан үнэ өртөгийн ажлыг тоог заасан заагаагүй, аль ч нөхцөлд тодорхойлсон байна. Гүйцэтгэгчийн бөглөөгүй орхисон үнэ өртөгийг ажлын хэмжээнд тусгасан бусад ажлуудад шингээсэн гэж ойлгоно.
 13. Гэрээний нөхцлийн дагуу шаардагдах бүх зардлыг ажлын тоо хэмжээнд тусгасан ажлуудад шингээсэн гэж үзэн ямар нэгэн ажил тодорхойлоогүй үлдээсэн тохиолдолд түүний үнэ өртөг нь холбогдох ажлын үнэ өртөгт шингэсэн гэж үзнэ.
 14. Ажлын тоо хэмжээнд тодорхойлсон магадлашгүй ажлын зардлыг зарцуулахад захиалагчийн зөвшөөрөл баталгааг авна.
 15. Тендерийн нийт үнэд НӨАТ тооцно. Захиалагчийн хяналтын зардал, магадлашгүй ажлын зардлыг төсөвт тусгаж өгнө.
 16. Тендерт оролцогч нь зохион хяналтын зардалыг тогтмол тусгаж өгөх бөгөөд инженер хайгуул, зураг төслийн үнийг хяналтын төсөвт тусгаснаар шууд тооцож ирүүлнэ
 17. /Техникийн тодорхойлолтыг хангаж буй талаар нотлох баримт ирүүлнэ, Тендер зарлагдсан өдрөөс хойшхи хугацаанд тодорхойлолтуудыг авсан байх шаардлагатай/.

Дээврийн ажлын ТББ

Хийгдэх ажлын жагсаалт

1. Дээвэрт ашиглах дулаалгын материалын бэлтгэл ажил
2. Гадаргуугийн бэлтгэл ажил
3. Гадаргууд хөрсжүүлэгч түрхлэг түрхэх
4. Уур ус тусгаарлагч дэвсэх
5. Хөөсөнцөр хавтангаар дулаалга хийх
6. Хөнгөн блокны нунтаг, керамзитаар налуу уклон гаргана.
7. Бэлтгэл бетоны хүчинтэгэх тор дэвсэх
8. Бэлтгэл бетоны ажил
9. Хаяавч бетоны ажил
10. Бетоны арчилгаа
11. Хөрсжүүлэгч хийх
12. 2 үе хар цаас наах
13. 1 үе чулуутай хар цаас наах
14. Цоройлтын ирмэгийг хамгаалах
15. Малгайвч өмсгөх

-Ажлын тоо хэмжээг хавсаргав:

Дээврийн ажлын ТББ

Тав. **ЗУРАГ**

Зургийн санамж

Зургаа. **ҮЕ ШАТНЫ АЖЛЫН ХУВААРЬ**

Ажил гүйцэтгэх график ирүүлэх

Долоо. **ЖИШИГ МАЯГТ**

ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр], [гэрээний нэр ба дугаар]-ыг [тендерийн үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр тендерийн баримт бичгийн дагуу гүйцэтгэхээр санал болгож байна.
2. Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш **45** хоногийн хугацаанд хүчинтэй байх ба та энэ хугацаа дуусахаас өмнө түүнийг сонгох боломжтой.
3. Гэрээг албан ёсоор байгуулах хүртэл энэхүү тендер болон түүнийг шалгарсан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл нь бидний хооронд хийгдсэн хэлцэл болно.
4. Бид гэрээний өрөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

**Хавсралт. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО
ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ**

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаarahгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/фак с	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

Найм. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | |
|---|---|
| 1. Гүйцэтгэгч ажил гүйцэтгэх | 1.1. Гүйцэтгэгч гэрээний тусгай нөхцөлд заасан ажлыг техникийн тодорхойлолт болон зургийн дагуу хийж гүйцэтгэнэ. |
| 2. Төслийн менежерийн шийдвэр | 2.1. Гэрээнд тусгайллан заагаагүй бол гэрээтэй холбогдсон аливаа асуудлыг захиалагчийг төлөөлөн төслийн менежер шийдвэрлэнэ. |
| 3. Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр ажил дууссан байх | 3.1. Гүйцэтгэгч ажлыг гэрээний тусгай нөхцөлд заасан өдөр эхлүүлж, өөрийн гаргасан ажлын хөтөлбөр болон төслийн менежерийн баталсан тодотгосон ажлын хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэн, ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр дуусгана. |
| 4. Аюулгүй байдал | 4.1. Гүйцэтгэгч ажлын талбай дээрх бүх үйл ажиллагааны аюулгүй ажиллагааг хангаж ажиллана.

4.2. Барьж байгаа барилга, байгууламжаа байгалийн болзошгүй гамшиг, гэнэтийн аюулаас хамгаалах бүх талын арга хэмжээг авч, өөрийн нь ажилтай холбогдуулж барилгын болон байгаль орчин, эрүүл ахуй, гол түймрийн хяналтын албанаас гаргасан хууль ёсны шаардлага, дүгнэлтийг хүлээн авч биелүүлнэ. |
| 5. Зааварчилгаа | 5.1. Төслийн менежерийн гаргах аливаа зааварчилгаа нь Монгол улсын хууль, тогтоомжид нийцсэн байх бөгөөд түүнийг гүйцэтгэгч биелүүлэх үүрэгтэй |
| 6. Маргааныг шийдвэрлэх | 6.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана. |
| Б. ХУГАЦААНЫ БОЛОН ЧАНАРЫН ХЯНАЛТ | |
| 7. Ажлын хөтөлбөр | 7.1. Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэхэд шаардлагатай бүх үйл ажиллагааны ерөнхий аргачлал, зохион байгуулалт, дэс дараалал, ажил гүйцэтгэх хугацаа болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан ажлын хөтөлбөрийг боловсруулж, гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд төслийн менежерт хүргүүлж батлуулна.

7.2. Ажлын хөтөлбөрийг төслийн менежер батлах нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Гүйцэтгэгч нь ажлын хөтөлбөрийг хянан засварлаад төслийн менежерт хэдийд ч дахин хүргүүлж болно. Хянан засварласан ажлын хөтөлбөрт өөрчлөлтийг тусгана. |
| 8. Зөрчил, гологдол илрүүлэх | 8.1. Төслийн менежер гүйцэтгэгчийн ажлыг шалгаж, илэрсэн зөрчил, гологдолын талаар түүнд мэдэгдэнэ. Энэхүү шалгалт нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Төслийн менежер зөрчил, гологдол байж болзошгүй гэж үзсэн аливаа ажилд зөрчил, гологдол хайх, уг ажлын далд хэсгийг нээж шалгалт, |

туршилт явуулах талаар зааварчилгааг гүйцэтгэгчид өгөх эрхтэй.

- | | |
|---|--|
| 9. Зөрчил, гологдол арилгах | 9.1. Төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан чанарын баталгаат хугацаа ¹ дуусахаас өмнө зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдлийг гүйцэтгэгчид өгнө. Чанарын баталгаат хугацааг зөрчил, гологдлыг арилгаж дуусах хүртэл сунгана. |
| 10. Зөрчил, гологдол арилгахгүй байх | 9.2. Зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдэл өгсөн тухай бүр гүйцэтгэгч уг зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж өөрийн зардлаар арилгана. |
| 10. Зөрчил, гологдол арилгахгүй байх | 10.1. Хэрэв гүйцэтгэгч зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж арилгаагүй бол төслийн менежер зөрчил, гологдол арилгахад шаардагдах зардлыг тооцож гүйцэтгэгчээс гаргуулна. |

B. ЗАРДЛЫН ХЯНАЛТ

- | | |
|---|--|
| 11. Үе шатны ажлын хуваарь | 11.1. Төслийн менежерийн шаардсаны дагуу гүйцэтгэгч үе шатны ажлын тодотгосон хуваарийг 14 хоногийн дотор бэлтгэж ирүүлнэ. Үе шатны ажлын хуваарь тусгагдсан үйл ажиллагаатай нийцсэн байна. |
| 12. Үе шатны ажлын хуваарийг өөрчлөх | 11.2. Ажлын талбай дахь материалын төлбөрийг тусад нь хийх бол гүйцэтгэгч ажлын талбайд нийлүүлсэн материалын тооцоог үе шатны ажлын хуваариас тусад нь гаргаж ирүүлнэ. |
| 13. Алданги | 12.1. Гүйцэтгэгчийн шийдвэрээр ажлын арга барил, эсхүл ажлын хөтөлбөрт гарсан өөрчлөлтийг тусгах зорилгоор гүйцэтгэгч үе шатны ажлын хуваарьт нэмэлт өөрчлөлт хийнэ. Өөрчлөлт хийхдээ үе шатны ажлын хуваарь дахь үнийг өөрчлөхгүй. |
| 13. Алданги | 13.1. Гүйцэтгэгч нь ажил дуусгахаар төлөвлөсөн өдрөөс хугацаа хоцорсон хоног тутамд гэрээний тусгай нөхцөлд заасан хувь хэмжээгээр алданги ² төлнө. Алдангийн нийт дүн гэрээний тусгай нөхцөлд заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. Захиалагч нь алдангийг гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс суутган авч болно. Алданги төлсөн нь гүйцэтгэгчийн хүлээсэн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. |

Г. ГЭРЭЭГ ДУУСГАХ

- | | |
|-------------------------|---|
| 14. Ажил дуусгах | 14.1. Гүйцэтгэгч нь ажил дууссан тухай мэдэгдэл гаргах хүсэлтийг төслийн менежерт тавих бөгөөд төслийн менежер ажил дууссан гэж үзвэл уг мэдэгдлийг гаргана. Гүйцэтгэгч гадна тохижилтын ажлыг бүрэн дуусгаж, ажлын явцад гудамж, зам, талбай сэтэлж, мод, цэцэрлэгжүүлэлтийг түр зайлцуулсан бол эдгээрийг бүрэн |
|-------------------------|---|

¹ Чанарын баталгаат хугацааг тогтоохдоо Иргэний хууль болон Барилгын тухай хуулийг баримтална.

² Алдангийг ихэвчлэн хоногт 0.05-0.10 хувиар тогтоох бөгөөд нийт дун нь гэрээний үнийн 5-10%-иас хэтрэх ёсгүй.

хэмжээгээр сэргээсэн байна.

- 15. Хүлээж авах** 15.1. Төслийн менежер ажил дууссан тухай мэдэгдэл гаргаснаас хойш захиалагч долоо хоногийн дотор ажлын талбай болон ажлыг хүлээж авна.
- 16. Эцсийн тооцоо** 16.1. Гүйцэтгэгч гэрээний дагуу төлөгдөх ёстoy гэж үзэж буй нийт төлбөрийн нарийвчилсан тооцоог гаргаж, чанарын баталгаат хугацаа дуусахаас өмнө төслийн менежерт хүргүүлнэ.
Төслийн менежер зөрчил, гологдол арилгасан тухай мэдэгдэл гаргаж, хэрэв гүйцэтгэгчийн ирүүлсэн тооцоо бүрэн гүйцэд, үнэн зөв бол уг тооцоог хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор гүйцэтгэгчид төлөх эцсийн төлбөрийг тодорхойлно.
Хэрэв тооцоо буруу байвал шаардлагатай запруулга, нэмэлт өөрчлөлтийн талаарх тайлбарыг 14 хоногийн дотор гаргаж гүйцэтгэгчид хүргүүлнэ. Хэрэв засвар хийж дахин ирүүлсэн эцсийн тооцоо нь шаардлага хангаагүй бол төслийн менежер гүйцэтгэгчид төлөх дүнг шийдвэрлэж төлбөрийн мэдэгдэл гаргана.
- 17. Ашиглалт, засвар, үйлчилгээний гарын авлага** 17.1. Гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийн зураг, далдлагдсан ажил, инженерийн шугам сүлжээ, технологийн тоног төхөөрөмжийг туршиж тохируулсан акт болон захиалагч шаардсан бол ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд хүлээлгэн өгнө.
17.2. Хэрэв гүйцэтгэгч 22.1-д заасан материалыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд ирүүлээгүй, эсхүл шаардлага хангаагүйн улмаас тэдгээрийг төслийн менежер батлаагүй бол гүйцэтгэгчид төлөх ёстай төлбөрөөс төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан үнийн дүнг суутгана.
- 18. Гэрээг цуцлах** 18.1. Захиалагч, эсхүл гүйцэтгэгч нөгөө тал нь гэрээг ноцтой зөрчсөн гэж үзвэл гэрээг цуцлах эрхтэй.
18.2. Дор дурдсан нөхцөлүүдийг гэрээний ноцтой зөрчил гэж үзэх бөгөөд эдгээрээр хязгаарлагдахгүй:
 - ажлын хөтөлбөрт ажил зогсоо тухай заагаагүй, түүнчлэн ажил зогсоо тухай шийдвэрийг төслийн менежер батлаагүй байхад гүйцэтгэгч ажлыг 28 буюу түүнээс дээш хоногийн хугацаагаар зогсоосон;
 - төслийн менежер ажлын явцыг зогсоо зааварчилгааг гүйцэтгэгчид өгсөн бөгөөд уг шийдвэрээ 28 хоногийн дотор цуцлаагүй;
 - захиалагч, эсхүл гүйцэтгэгч дампуурсан, эсхүл өөрчлөн байгуулагдах, нэгдэхээс бусад зорилгоор татан буугдсан;
 - тодорхой зөрчил, гологдлыг арилгаж чадаагүй нь гэрээний

	<p>ноцтой зөрчил болохыг төслийн менежер гүйцэтгэгчид мэдэгдсэн бөгөөд гүйцэтгэгч нь уг зөрчил, гологдлыг заасан хугацаанд нь багтаан арилгаж чадаагүй;</p> <p>(д) гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийг гэрээний тусгай нөхцөлд заасан алдангийн дээд хэмжээ төлөх хугацаагаар хоцроосон.</p>
	<p>18.3. Гэрээг цуцалсан тохиолдолд гүйцэтгэгч ажлыг даруй зогсоож, ажлын талбайн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангаж, түүнийг аль болох түргэн хугацаанд чөлөөлнө.</p>
19. Гэрээг цуцалсан үед хийх төлбөр	<p>19.1. Гүйцэтгэгч гэрээг ноцтой зөрчсөний улмаас гэрээ цуцлагдсан бол төслийн менежер гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээг нотолсон мэдэгдэл гаргана. Ингэхдээ мэдэгдэл олгосон өдөр хүртэл дуусаагүй ажлын гэрээний тусгай нөхцөлд заасан хэмжээг дээрх үнэлгээнээс хасна. Нэмэлт алданги гүйцэтгэгчид ногдуулахгүй.</p> <p>19.2. Гэрээг захиалагчийн шаардлагаар, эсхүл гэрээг захиалагч ноцтой зөрчсөний улмаас цуцалсан бол гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээ, тоног төхөөрөмжийг ажлын талбайгаас гаргах бодит зардал, ажлын зорилгоор хөлслөн ажиллуулсан гүйцэтгэгчийн ажилтнуудыг буцаахтай холбогдсон зардал, түүнчлэн ажлыг хадгалах, хамгаалахтай холбогдсон зардал зэрэг гүйцэтгэгчийн зардлыг төслийн менежер хянаж мэдэгдэл гаргана.</p>
20. Гүйцэтгэлээ с чөлөөлөх	<p>20.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчиний нөхцөл байдлын улмаас гэрээг гүйцэтгэх боломжгүй болсон бол төслийн менежер үүнийг гэрчилнэ. Гүйцэтгэгч нь энэхүү мэдэгдлийг хүлээн авсны дараа ажлын талбайн бүрэн бүтэн байдлыг хангаж, ажлыг аль болох богино хугацаанд зогсооно. Захиалагч уг мэдэгдэл гарахаас өмнө хийгдсэн ажил болон түүний дараа захиалгаар гүйцэтгэсэн ажлын хөлсийг гүйцэтгэгчид төлнө.</p>

Ес. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ³

ГЕ	Гэрээний нэр болон бүртгэлийн дугаар: “Орон сууцны 3-р хороолол 23-р байр 2-р блокын дээвэр” ОР-28/2018
ГЕ	Орон сууцны 3-р хороолол 23-р байр 2-р блокын дээвэр засварын ажлаас бүрдэнэ.
ГЕ.	Төслийн менежер нь [Гэрээ хийгдэх үед томилогдоно]
ГЕ	Ажил эхлэх өдөр [Гэрээ байгуулагдсан өдрөөс эхлэнэ.] Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр [1-28 хоног хүртэл] ⁴ 2019.07.30
ГЕ	Гүйцэтгэгч гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш [5] хоногийн дотор тодотгосон ажлын хөтөлбөрийг гаргана.
ГЕ	Чанарын баталгаат хугацаа [1 жил] хоног байна.
ГЕ	Алданги ногдуулах хэмжээ хоногт гэрээний үнийн [0.1 хувь] байна. ⁵ Нийт ажилд ногдуулах алдангийн дээд хэмжээ нь гэрээний үнийн [5 хувь] байна.
ГЕ	Ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг [2019.07.30]-ны дотор гаргаж өгнө. шаардлагагүй
	Гүйцэтгэлийн зургийг [[2019.07.30]-ны дотор гаргаж өгнө.
	Гүйцэтгэлийн зургийг, эсхүл ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг хугацаанд нь гаргаж өгөөгүй тохиолдолд суутгах төлбөрийн хэмжээ [нийт үнийн дунгийн 2%] байна.
ГЕ	Ажил дуусгахад захиалагчаас гарах нэмэлт зардлыг дуусаагүй ажлын [100]-иар тооцно.

ГЭРЭЭНИЙ МАЯГТ

ЗАХИАЛАГЧ

ГҮЙЦЭТГЭГЧ

(Тамга, тэмдэг)

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

(Албан тушаал)

[Төндөр шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Төндөр шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас [захиалагчийн нэр] (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас [гүйцэтгэгчийн хот, улс, гүйцэтгэгчийн нэр] (цаашид “гүйцэтгэгч” гэх) дараах эйлийг харилцан тохиролцож _____ оны _____ сарын _____-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний хууль, Барилгын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу инженерийн хийцтэй барилга байгууламж барих, засварын ажил гүйцэтгэх, тоног төхөөрөмж суурилуулахтай холбогдон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

2. Захиалагч нь [гэрээний нэр, дугаар]-г (цаашид “ажил” гэх) [гэрээний үнийг тоогоор болон үсгээр] (цаашид “гэрээний үнэ” гэх) гүйцэтгэхээр ирүүлсэн гүйцэтгэгчийн тендерийг үүгээр

Дээврийн ажлын ТББ

хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ буюу ажлын нийт төсөвт өртөг нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

3. Гэрээний нийт дүн: _____ төгрөг. Үүнээс: /Аль тохирохыг нь бөглөнө, бусдыг нь устгана/

Улсын төсвөөс: 20.... онд: _____ төгрөг; 20.... онд: _____ төгрөг;

Орон нутгийн төсвөөс: 20.... онд: _____ төгрөг; 20.... онд: _____ төгрөг;

Өөрийн хөрөнгө: 20.... онд: _____ төгрөг; 20.... онд: _____ төгрөг.

4. Гүйцэтгэгч нь _____ байршилтай _____ хүчин чадал бүхий _____ ам.метр талбай / _____ шоо метр эзлэхүүн/-тай, _____ суурь, _____ хана, _____ хучилттай, _____ давхар _____ барилга угсралт /барилгын засвар, тоног төхөөрөмж суурилуулах/-ын ажлыг _____ инженерийн шугам сүлжээ /дулаан, цахилгаан, цэвэр, бохир усан хангамж/, _____ туслах барилга /бусад ажил/-ын хамт _____ оны _____ дугаар сарын _____-ны өдөр эхэлж, _____ оны _____ дугаар сарын _____-ны өдөр ашиглалтад оруулна.

5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

- 5.1. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
- 5.2. Бусад шаардлагатай баримт бичиг ;
- 5.3. Үнийн санал
- 5.4. Гэрээний тусгай нөхцөл;
- 5.5. Гэрээний ерөнхий нөхцөл;
- 5.6. Техникийн тодорхойлолт;
- 5.7. Зураг;
- 5.8. Гүйцтгэгчийн ирүүлсэн үе шатны ажлын хуваарь :
- 5.9. Санхүүжилтийн хуваарь;
- 5.10. Ажил гүйцэтгэх хуваарь.

Гэрээ нь энд дурдсан ажлыг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний бичиг баримтууд хоорондоо зөрчилдвэл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

Дээврийн ажлын ТББ

6. Захиалагч, гүйцэтгэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг хүлээнэ.

7. Гүйцэтгэгч нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдол арилгах үүрэг хүлээнэ.

8. Захиалагч нь гэрээний дагуу гүйцэтгэгчийн хийх ажил болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг, хүлээнэ.

9. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг] _____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]

[Утас/факсын дугаар]

[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг] _____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]

[Утас/факсын дугаар]

[Харилцагч банкны нэр, дансны дугаар]